



МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 1/90

Улаанбаатар хот

Г  
Мэдээлэл, харилцаа холбооны улсын  
албаны гамшигаас хамгаалах  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Гамшигаас хамгаалах хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ч.Золбаяр)-д даалгасугай.



1522006901



Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын  
2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
10:00 дугаар тушаалын хавсралт

## МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН

## **АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....</b>	<b>2</b>
1.1. Зорилго.....	2
1.2. Төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим .....	2
1.3. Хамрах хүрээ .....	2
1.4. Танилцуулга.....	3
1.4.1. Салбарын өнөөгийн байдал.....	3
1.4.2. Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалт.....	5
<b>БҮЛЭГ 2. ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ .....</b>	<b>16</b>
2.1. Эрсдэлийн үнэлгээ.....	16
2.2. Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо (MXX)-ны газрын зураглал .....	16
2.3. Гамшгийн үед мэдээлэл, харилцаа холбооны тэсвэрлэх чадвар, нөөц .....	16
2.4. Олон улсын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, оролцогч талууд.....	16
<b>БҮЛЭГ 3. ГАМШГИЙН ҮЕИЙН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ .....</b>	<b>18</b>
3.1. Гамшгийн үед ажиллах байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт.....	18
3.2. Гамшгийн үеийн зарлан мэдээлэл .....	19
3.2.1 Улсын алба, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг цуглуулах.....	19
3.2.2. Бүх нийтэд зарлан мэдээлэх.....	20
3.3. Хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах.....	20
3.4. Мэдээ, мэдээлэл цуглуулах дамжуулах.....	20
<b>БҮЛЭГ 4. СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ .....</b>	<b>21</b>
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>23</b>

## БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Зорилго

Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөө /цаашид “төлөвлөгөө” гэх-/ний зорилго нь гамшигийн үед мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний тасалдалгүй, бэлэн байдлыг хангах, гамшигийн эрсдэлийг бууруулах, гамшигаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад онцгой байдлын байгууллага, гамшигаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн харилцан хамтын ажиллагаа, удирдлага зохицуулалтаар хангахад оршино.

Энэхүү төлөвлөгөө нь тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, гамшигийн үед мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлыг хангах арга хэмжээг тухайн салбарын хэмжээнд зохион байгуулах улсын албаны удирдлагын баримт бичиг болно.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээний зардлыг Гамшигаас хамгаалах тухай хуулийн 51.2, 51.4-т заасны дагуу санхүүжүүлнэ.

### 1.2. Төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим

Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшигаас хамгаалах төлөвлөгөө нь Монгол Улсын гамшигаас хамгаалах төлөвлөгөөтэй нийцсэн;

Гамшигаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, дунд хугацааны стратеги баримт бичиг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт болон бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдсан;

Гамшигаас хамгаалах албаны чадавх болон эрсдэлийн үнэлгээ, тойм судалгаанд суурилсан;

Төлөвлөгөө нь үүсэж болзошгүй болон үүссэн гамшигийн үед урьдчилан төлөвлөгдсөн, шуурхай, уян хатан, тасралтгүй байх, хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй ашиглах үндсэн зарчмын хүрээнд удирдлага, зохион байгуулалт, бэлэн байдал, гамшигаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа гэсэн үе шатаар төлөвлөгдсөн.

### 1.3. Хамрах хүрээ

Энэхүү төлөвлөгөөг Монгол Улсын нийт нутаг дэвсгэр, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хүн ам олноор суурьшсан газрыг хамарсан байгалийн аюулт үзэгдэл, мал амьтны халдварт өвчний улмаас хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах, мал, амьтан олноор хоргодах, хүн, мал, амьтны аюулгүй байдал алдагдах зэргээр улс орны нийгэм эдийн засагт ноцтой хохирол учруулж болзошгүй болон учирсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ашиглана.

Төлөвлөгөөг дор дурдсан гамшгийн үед хэрэгжүүлнэ. Үүнд:

Гал түймэр

- Ой, хээрийн гал түймэр
- Онц чухал мэдээллийн дэд бүтцийн гал түймэр

Байгалийн аюулт үзэгдэл

- Газар хөдлөлт
- Yer
- Ган
- Хүчтэй цасан болон шороон шуурга

Гоц халдварт өвчин

- Хүн болон мал, амьтны гоц халдварт өвчин гарах

Хуульд заасан бусад

- Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний тасалдал
- Эрчим хүчний үйлчилгээний тасалдал
- Кибер халдлага
- Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үе

Энэхүү төлөвлөгөө нь Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төлөвлөгөөний хувийг Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба, Онцгой байдлын ерөнхий газарт тус тус хадгална. Төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийнэ.

#### 1.4. Танилцуулга

##### 1.4.1. Салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөгжил өнөөг хүртэлх хугацаанд хөдөө, орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх, техник технологийн суурь дэд бүтцийг өргөтгэн шилэн кабелийн сүлжээ 49,943 км, радио релейний сүлжээний тархалт 8400 км-т хүрч, манай улсын бүх аймаг, сумын төв, томоохон суурин газрууд хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдсон. Үүрэн холбоо хэрэглэгчдийн тоо 2021 оны сүүлийн хагас жилийн байдлаар 4 сая 687 мянягад хүрсэн.

Интернэтийн бүтцийн хувьд Монгол Улсад интернэтийн үйлчилгээ нэвтэрсэн 26 жилийн хугацаанд 70 гаруй компани интернэтийн үйлчилгээ эрхэлж, гадаад гарцын урсгалын хэмжээ 780 Г бит/сек, интернэт хэрэглэгчдийн тоо давхардсан оогоор 5,450.61 мянга хүрснээс 94,41 хувь нь хөдөлгөөнт өргөн зурvasын үйлчилгээг хэрэглэж байна.

Монгол Улсын хэмжээнд нийт 260 өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоноос Монголын Үндэсний олон нийтийн телевизийн 5, олон нийтийн радиогийн 4, Улаанбаатар хотод өргөн нэвтрүүлгийн телевизийн 18, арилжааны телевизийн 62, төлбөртэй телевизийн 11, радиогийн 33, орон нутагт телевизийн 64, радиогийн 26, мөн радио, телевизийн газрын сүлжээний 2, олон суваг дамжуулах 35 үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус байна. Монгол Улсын нийт өрхийн 97.3 хувь нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг радио, телевизийн газрын сүлжээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр дамжуулан хүлээн авч үзэж байна. Түүнчлэн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр гадаадын дахин дамжуулж байгаа 199 сувгийг хэрэглэгч хүлээн авч байна.

Улс орон даяар урт, дунд, богино долгионы их чадлын 10 станцаар үндэсний олон нийтийн радиогийн 1, 2 дугаар хөтөлбөрийг дамжуулж байгаа бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 50 гаруй хувь нь дунд сонсголын, хүн амын 40 гаруй хувь нь найдвартай сонсголын бүсэд хамрагдаж байна.


Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 95 аж ахуйн нэгж, байгууллага шуудангийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хэдий ч, шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагууд орон нутагт шуудангийн үйл ажиллагаа явуулахгүй байна. Улмаар зөвхөн хүн ам нягт суурьшсан Улаанбаатар хотын жижиг зах зээлд хэт олон өрсөлдөгч үйл ажиллагаа явуулж байгаа боловч, зөвхөн шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигч алслагдсан бүс нутагт, хамгийн зардал өндөртэй хэсэгт нь ажиллаж, алдагдал хүлээж байгаа нь үндсэн сүлжээ эзэмшигчийн найдвартай, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг эрсдэлд оруулж байна.

Олон Улсын Цахилгаан холбооны байгууллагаас 2 жил тутам гаргадаг "Кибер аюулгүй байдлын индекс"-ээр Монгол Улс 2020 онд 193 орноос 120 дугаар байрыг эзэлсэн байна. УИХ-аас "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай", "Кибер аюулгүй байдлын тухай хууль"-ийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан нь Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх үндсэн нөхцөл болж байна. Энэхүү хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахад дагаж мөрдөх журам, аргачлал, шаардлагыг боловсруулан батлуулах, хүний нөөцийг чадавхжуулах, иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв байгуулах болон гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

#### 1.4.2. Гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалт

Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба нь Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Улсын онцгой комиссын үйл ажиллагаатай уялдуулан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Зураг 1-д Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны бүтцийг үзүүлэв.

Зураг 1. Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны бүтэц



Цахим хөгжил, харилцаа холбооны сайд нь гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны төлөвлөлт, бэлэн байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааны хүрээнд удирдлага зохион байгуулалтаар хангах Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба (цаашид "Улсын алба" гэх)-ны даргын үргийг гүйцэтгэнэ.

Улсын алба нь дараах үндсэн чиг үргийн хүрээнд Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны штаб (цаашид "штаб" гэх) болон мэргэжлийн ангийг гамшгийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

**a) Гамшгийн өмнөх үед:**

- Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны тасалдалгүй ажиллагааг хангах төлөвлөгөө боловсруулж батлах;
- Улсын албаны Штабын даргын тушаалаар мэргэжлийн ангиудыг томилон ажиллуулах;
- Мэргэжлийн ангийг шаарддагдах техник, тоног төхөөрөмж, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;
- Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;
- Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх.

**b) Гамшгийн үед:**

- Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Гамшгийн цаг үеийн мэдээлэл, харилцаа холбооны тасалдалгүй ажиллагааг хангах төлөвлөгөө батлах;
- Гамшгийн цаг үеийн мэдээлэл, харилцаа холбооны тасалдалгүй ажиллагааг хангах төлөвлөгөөний дагуу мэргэжлийн ангиудад үүрэг өгч ажиллуулах, шаардлагатай үед олон улсаас тусlamж дэмжлэг авах арга хэмжээг зохион байгуулах;
- Мэргэжлийн ангиудаас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн, шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг УОК-д танилцуулан, шийдвэрлүүлэх;
- Мэргэжлийн ангиудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний амрах байр, цэвэр ус, хоол хүнс, бусад шаардлагатай зүйлсээр хангах;
- Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангахад онцгой анхаарах;
- Сайн дурын хэсгийг зөвлөмж, удирдамжаар хангах.

**c) Гамшгийн дараах үед:**

- Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах, тайлан мэдээг гаргах, УОК-д хүргүүлэх;
- Бэлэн байдлын үзлэг хийх, чадавхыг дээшлүүлэх;
- Өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд шилжих.

Хүснэгт 1-д Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны бүрэлдэхүүн, түүний чиг үүрэг, орлон ажиллах албан тушаалтны талаарх мэдээллийг харуулав.

Хүснэгт 2-т Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны штабын бүрэлдэхүүн, түүний чиг үүрэг, орлон ажиллах албан тушаалтны талаарх мэдээллийг харуулав.

*Хүснэгт 1. Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны бүрэлдэхүүний чиг үүрэг*

№	Томилгоот албан тушаал	Албан тушаал	Орлох албан тушаалтан	Гүйцэтгэх чиг үүрэг
1	Улсын албаны дарга	Цахим хөгжил,харилцаа холбооны сайд	Цахим хөгжил,харилцаа холбооны дэд сайд	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг, Монгол Улсын Их Хурлын Тогтоол Онц байдлын тухай хууль, хуулийн хүрээнд гаргасан шийдвэр, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр нэгдсэн удирдлагаар хангах;</li> <li>- Албыг удирдах;</li> <li>- Штабын удирдлагаар хангах;</li> <li>- ҮАБЗ-ийн шийдвэрийг МХХ-ны салбарт хэрэгжүүлэх цаг үеийн төлөвлөлтийг батлах, хэрэгжилтийг хангуулах;</li> <li>- Шаардлагатай үед олон улсын дэмжлэг тусламж авах асуудлыг шийдвэрлүүлэх;</li> <li>- ҮАБЗ болон УОК-д тайлан, танилцуулга хийх, асуудал шийдвэрлүүлэх;</li> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлыг хангахад шаардлагатай зардал, төсөв, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх асуудлыг Засгийн газар болон УОК-р шийдвэрлүүлэх.</li> </ul>
2	Гишүүн/Штабын дарга	ЦХХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ЦХХХЯ-ны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын албаны дотоод үйл ажиллагааг хангах;</li> <li>- Штабыг зохион байгуулалтаар хангах;</li> <li>- Цаг үеийн төлөвлөгөө боловсруулах;</li> <li>- Улсын албанаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөлтийн хэрэгжилтийг мэргэжлийн ангиар хангуулах, тайлан, танилцуулга авах;</li> </ul>
3	Гишүүн ХХЗХ-ны төлөөлөл	ХХЗХ-ны дарга	ХХЗХ-ны Ажлын албаны дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Салбарын байгууллагуудаас авч хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэх, үйлчилгээ эрхлэгчдээс авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээллээр Улсын албыг хангах;</li> <li>- Гамшигийн үед мэдээлэл, харилцаа холбооны салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг авахад үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх;</li> </ul>

				<ul style="list-style-type: none"> <li>- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшилд буй сүлжээ, дэд бүтэц, үйлчилгээний техникийн талаарх мэдээллийг газар зүйн мэдээллийн системд нэгтгэх ажлыг зохион байгуулах, цаг үеийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай орон зайн мэдээллийн системийн бэлэн байдлыг хангах.</li> </ul>
4	Санхүү, хангалт хариуцсан гишүүн	ЦХХХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга	ЦХХХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг шаардагдах техник, материал хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлыг хангахад шаардлагатай зардал, төсөв, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх асуудлыг боловсруулан Улсын албанад хүргүүлэх.</li> <li>- Гамшгийн хор уршигийг арилгах ажиллагаанд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;</li> <li>- Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах;</li> <li>- Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг байр, цэвэр ус, хоол хүнс, эм, ороох боох материалаар хангах ажлыг зохион байгуулах;</li> <li>- Хохирлын үнэлгээг хийж, мэргэжлийн ангийн даргыг мэдээллээр хангах;</li> <li>- Гамшгийн хор уршигийг арилгах ажиллагаанд зарцуулсан санхүүгийн тайланг улсын албаны даргад танилцуулах.</li> </ul>
5	Радио өргөн нэвтрүүлгийн мэргэжлийн ангийн ахлагч	ЦХХХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга	ЦХХХЯ-ны Харилцаа холбооны хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ үйлчилгээ, дэд бүтцийн аюулгүй байдал, бэлэн байдлыг хангах;</li> <li>- Салбарын байгууллагуудыг сүлжээ, үйлчилгээний бэлэн байдал, тасалдалгүй ажиллагаа, сэргээн босгох үйл ажиллагааны зохицуулалтаар хангах;</li> </ul>
6	Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжлийн ангийн ахлагч	ЦХХХЯ-ны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	ЦХХХЯ-ны Онц чухал мэдээллийн дэд бүтцийн асуудал хариуцсан шинжээч	<ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг тасалдалгүй хүргэхэд сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх;</li> </ul>

7	Харилцаа холбооны мэргэжлийн ангийн ахлагч	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны Захиргаа удирдлагын нэгжийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Штабаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөлтийн биелэлтийг хангуулах;</li> <li>- Улсын онцгой комисс, мэргэжлийн албадаас өгсөн үүрэг даалгаврыг цаг алдалгүй биелүүлэх;</li> <li>- Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, дайчилгаанд хүн хүчний дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Гамшиг, аюулыг зарлан мэдээлэхэд өөрийн сүлжээг ашиглуулах;</li> <li>- Гамшгийн үед харилцаа холбооны нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлэх зохицуулалтын системийг бүрдүүлэх;</li> <li>- Мэргэжлийн ангид ажиллах бие бүрэлдэхүүнийг томилох,</li> <li>- Мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бусэд ажиллах;</li> <li>- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.</li> <li>- Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах.</li> </ul>
8	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан гишүүн	ЦХХХЯ-ны Мэргэжлийн хяналт хариуцсан нэгжийн дарга	ЦХХХЯ-ны Гамшгийн хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн үед улсын алба, штаб, мэргэжлийн ангийг цуглуулах;</li> <li>- Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;</li> <li>- Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж шалгах, тухай бүр тодотгох;</li> <li>- Бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшүүлэх;</li> <li>- Гамшгийн голомтод бүх төрлийн холбоо зохион байгуулах, мэргэжлийн ангийн даргыг холбоо, мэдээллээр хангах;</li> <li>- Дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах;</li> <li>- Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх, нөхөн сэлбэх;</li> </ul>

**Хүснэгт 2. Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны штабын бүрэлдэхүүний чиг үүрэг**

№	Штабын бүрэлдэхүүний томилгоо	Үүрэг гүйцэтгэх албан тушаалтан	Орлох албан тушаалтан	Гүйцэтгэх үүрэг
1	Штабын дарга	ЦХХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга	ЦХХХЯ-ны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгжийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн ангиудын даргыг томилох;</li> <li>- Штабыг зохион байгуулалтаар хангах;</li> <li>- Улсын албанаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөлтийн хэрэгжилтийг мэргэжлийн ангиар хангуулах, тайлан, танилцуулга өгөх, асуудал шийдвэрлүүлэх;</li> <li>- Эрсдэлийн үнэлгээ болон гамшгийн эрсдэлийн тойм судалгаанд үндэслэн цаг үеийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг томилох, төлөвлөгөөг батлах арга хэмжээ авах;</li> <li>- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бусад албадтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;</li> <li>- Гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх;</li> <li>- Гамшиг болон аюулт үзэгдэл, ослын үед салбарыг ажлын тусгай горим болон гамшигаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх;</li> <li>- Гамшигийн голомтын бүсэд хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;</li> <li>- Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр шуурхай хангах.</li> </ul>
2	Штабын орлогч дарга	ЦХХХЯ-ны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгжийн дарга	ЦХХХЯ-ны захиргааны хариуцсан Төрийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад улсын орон нутгийн албанаас гаргуулан авч, мэдээллийн сан бүрдүүлэх улсын албаны бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;</li> <li>- Улсын албаны удирдлагын баримт бичгийг төлөвлөх, хүч хэрэгслийг томилж ажиллуулах;</li> <li>- Гамшигаас хамгаалах дайчилгаагаар ажиллах хүч, хэрэгслийн судалгаа гаргах, тодотгох, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;</li> <li>- Гамшигийн үеийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</li> </ul>

					<ul style="list-style-type: none"> <li>- Гамшгаас хамгаалах чиглэлээр тушаал, албан даалгавар, удирдамж гарах, биелэлтийг шалгах, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, заавар боловсруулж батлах, хэрэгжүүлэх,</li> </ul>
3	Штабын гишүүн ХХЗХ-ны төлөвлөл	ХХЗХ-ны дарга	ХХЗХ-ны албаны дарга	Ажлын	<ul style="list-style-type: none"> <li>- Салбарын байгууллагуудыг сүлжээ, үйлчилгээний бэлэн байдал, тасалдалгүй ажиллагаа, сэргээн босгох үйл ажиллагааны зохицуулалтаар хангах;</li> <li>- Гамшгийн үед харилцаа холбооны нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлэх зохицуулалтын системийг бүрдүүлэх;</li> <li>- Гамшгийн үед мэдээлэл, харилцаа холбооны салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг авахад үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшилд буй сүлжээ, дэд бүтэц, үйлчилгээний техникийн талаарх мэдээллийг газар зүйн мэдээллийн системд нэгтгэх ажлыг зохион байгуулах, цаг үеийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай орон зайн мэдээллийн системийн бэлэн байдлыг хангах.</li> </ul>
4	Штабын Санхүү, хангалт хариуцсан гишүүн	ЦХХХЯ-ны Төрийн захиргааны удирдлагыг газрын дарга	ЦХХХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга		<ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг шаардагдах техник, материал хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>- Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гарах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;</li> <li>- Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах;</li> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлыг хангахад шаардлагатай зардал, төсөв, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх асуудлыг боловсруулан штабын даргад танилцуулах;</li> <li>- Хохирлын үнэлгээг хийж, штабын даргыг мэдээллээр хангах;</li> <li>- Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд зарцуулсан санхүүгийн тайланг штабын даргад танилцуулах.</li> </ul>

5	Радио өргөн нэвтрүүлгийн мэргэжлийн ангийн ахлагч	ЦХХХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга	ЦХХХЯ-ны Харилцаа холбооны хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ үйлчилгээ, дэд бүтцийн аюулгүй байдал, бэлэн байдлыг хангах;</li> <li>- Салбарын байгууллагуудыг сүлжээ, үйлчилгээний бэлэн байдал, тасалдалгүй ажиллагаа, сэргээн босгох үйл ажиллагааны зохицуулалтаар хангах;</li> <li>- Гамшигийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг тасалдалгүй хүргэхэд сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Штабаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөлтийн биелэлтийг хангуулах;</li> <li>- Улсын онцгой комисс, мэргэжлийн албадаас өгсөн үүрэг даалгаврыг цаг алдалгүй биелүүлэх;</li> <li>- Гамшигийн үеийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, дайчилгаанд хүн хүчиний дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Гамшиг, аюулыг зарлан мэдээлэхэд өөрийн сүлжээг ашиглуулах;</li> <li>- Гамшигийн үед харилцаа холбооны нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлэх зохицуулалтын системийг бүрдүүлэх;</li> <li>- Мэргэжлийн ангид ажиллах бие бүрэлдэхүүнийг томилох,</li> <li>- Мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшигийн голомтын бүсэд ажиллах;</li> <li>- Гамшигийн эрсдэлийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийн дагуу гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.</li> <li>- Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах.</li> </ul>
6	Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжлийн ангийн ахлагч	ЦХХХЯ-ны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	ЦХХХЯ-ны Онц чухал мэдээллийн дэд бүтцийн асуудал хариуцсан шинжээч	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ үйлчилгээ, дэд бүтцийн аюулгүй байдал, бэлэн байдлыг хангах;</li> <li>- Салбарын байгууллагуудыг сүлжээ, үйлчилгээний бэлэн байдал, тасалдалгүй ажиллагаа, сэргээн босгох үйл ажиллагааны зохицуулалтаар хангах;</li> <li>- Гамшигийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг тасалдалгүй хүргэхэд сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Штабаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөлтийн биелэлтийг хангуулах;</li> <li>- Улсын онцгой комисс, мэргэжлийн албадаас өгсөн үүрэг даалгаврыг цаг алдалгүй биелүүлэх;</li> <li>- Гамшигийн үеийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, дайчилгаанд хүн хүчиний дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Гамшиг, аюулыг зарлан мэдээлэхэд өөрийн сүлжээг ашиглуулах;</li> <li>- Гамшигийн үед харилцаа холбооны нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлэх зохицуулалтын системийг бүрдүүлэх;</li> <li>- Мэргэжлийн ангид ажиллах бие бүрэлдэхүүнийг томилох,</li> </ul>

				<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд ажиллах;</li> <li>- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.</li> <li>- Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах.</li> </ul>
7	Харилцаа холбооны мэргэжлийн ангийн ахлагч	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний гүйцэтгэх захирал	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний Захиргаа удирдлагын нэгжийн дарга	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ үйлчилгээ, дэд бүтцийн аюулгүй байдал, бэлэн байдлыг хангах;</li> <li>- Салбарын байгууллагуудыг сүлжээ, үйлчилгээний бэлэн байдал, тасалдалгүй ажиллагаа, сэргээн босгох үйл ажиллагааны зохицуулалтаар хангах;</li> <li>- Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг тасалдалгүй хүргэхэд сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Штабаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөлтийн биелэлтийг хангуулах;</li> <li>- Улсын онцгой комисс, мэргэжлийн албадаас өгсөн үүрэг даалгаврыг цаг алдалгүй биелүүлэх;</li> <li>- Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, дайчилгаанд хүн хүчиний дэмжлэг үзүүлэх;</li> <li>- Гамшиг, аюулыг зарлан мэдээлэхэд өөрийн сүлжээг ашиглуулах;</li> <li>- Гамшгийн үед харилцаа холбооны нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлэх зохицуулалтын системийг бүрдүүлэх;</li> <li>- Мэргэжлийн ангид ажиллах бие бүрэлдэхүүнийг томилох,</li> <li>- Мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд ажиллах;</li> <li>- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.</li> <li>- Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах.</li> </ul>
8	Штабын нарийн бичгийн дарга	ЦХХХЯ-ны Мэргэжлийн хяналт хариуцсан нэгжийн дарга	ЦХХХЯ-ны Гамшгийн хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн үед улсын алба, штаб, мэргэжлийн ангийг цуглуулах;</li> <li>- Штабыг мэдээллээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд ажиллах;</li> <li>- Гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох улсын болон орон нутгийн алба, байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;</li> <li>- Мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн, гамшгаас хамгаалах чиглэлээр улсын албанаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Онцгой байдлын асуудал</li> </ul>

			<p>эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх;.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн ангиудын хийсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийн дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;</li> <li>- Алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж шалгах, тухай бүр тодотгох, дадлага сургууль хийлгэх, гамшгийн голомтод бүх төрлийн холбоо зохион байгуулах, албаны даргыг холбоо, мэдээллээр хангах;</li> <li>- Дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах;</li> <li>- Гамшигаас хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага боловсруулах;</li> <li>- Улсын албаны хэмжээнд бэлэн байдлын үзлэг зохион байгуулахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>- Гамшигаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тушаал шийдвэр, албан даалгавар, сэргээлүүлэг, гамшиг, ослын нөхцөл байдал, хор уршигийг арилгах арга хэмжээний талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдад таниулах, сурталчлах, гамшгийн аюулаас сэргээлүүлэх сурталчилгааны материалыаар хангах зэрэг ажлыг зохион байгуулах.</li> <li>- Алба болон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах;</li> <li>- Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;</li> <li>- Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгالت, засвар үйлчилгээ хийх;</li> <li>- Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт бодисын судалгааг гаргаж, бүртгэл хөтлөх, тэдгээрийн эргэлтэд хяналт тавих, объектын харуул хамгаалалтад хяналт тавих;</li> </ul>
--	--	--	--

Хүснэгт 3-т Мэдээлэл, харилцаа холбооны салбарын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, түүний чиг үүрэг, орлон ажиллах албан тушаалтны талаарх мэдээллийг харуулав. Гамшигийн үеийн мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлыг хангах салбарын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги нь мэдээлэл, харилцаа холбооны тасалдалгүй байдлыг хангах зорилгоор урьдчилан сэргийлэх, гамшигийн үед гамшигийн голомтыг харилцаа холбоогоор хангах, хор уршигийг арилгах, сэргээн босгох ажиллагааг хангах чиг үүрэгтэй байна.

**Хүснэгт 3. Мэдээлэл, харилцаа холбооны мэргэжлийн анги бүхэлдэхүүний чиг үүрэг**

<b>Мэргэжлийн ангийн нэр</b>	<b>Мэргэжлийн ангийн ахлагч</b>	<b>Мэргэжлийн ангийн гишүүн байгууллага</b>	<b>Гүйцэтгэх үүрэг</b>
Радио өргөн нэвтрүүлгийн мэргэжлийн ангийн ахлагч	ЦХХХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга	<ul style="list-style-type: none"> <li>- РТҮС УТҮГ</li> <li>- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид</li> <li>- Сансырын холбооны үйлчилгээ үзүүлэгчид</li> </ul>	<p><b>Гамшигийн өмнө</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гамшигийн голомтод ажиллах мэргэжлийн ангийн цаг үеийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх;</li> <li>- Жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн мэдээг маягтын дагуу гаргаж, штабт хүргүүлэх;</li> <li>- Мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх саналыг боловсруулж, байгууллагын удирдлагад танилцуулах, гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нөөц бурдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа гаргаж, хангах асуудлыг шийдвэрлүүлэх;</li> <li>- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах;</li> <li>- Мэргэжлийн ангийн гишүүдийн бие бүрэлдэхүүний, сэтгэл зүйн бэлэн байдал, бүлэг, хэсгүүдийн харилцан шуурхай үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх;</li> <li>- Мэргэжлийн ангийн гамшигийн голомтод ажиллах нөхцөлийг бурдүүлэх,</li> </ul> <p><b>Гамшигийн үед</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Штабыг үнэ зөв мэдээллээр хангах;</li> <li>- Штабаас өгсөн үүрэг даалгавар болон төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж тайлан, мэдээг нэгтгэн хүргүүлэх;</li> <li>- Гамшигийн голомтод үүрэг гүйцэтгэх, нөхцөл байдлыг үнэлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;</li> <li>- Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшуулшгүй сэргээн босгох ажилд оролцох, тэдгээрийн аюулгүй ажиллагааг хангах;</li> <li>- Бусад төрөл, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллах,</li> </ul> <p><b>Гамшигийн дараа</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нөхцөл байдлын үнэлгээ хийх, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, хохирлыг арилгах арга хэмжээ авах;</li> <li>- Шаардлагатай зардал, төсөв, хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан штабт танилцуулах.</li> </ul>
Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжлийн ангийн ахлагч	ЦХХХЯ-ны Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	<ul style="list-style-type: none"> <li>- ҮДТ УТҮГ</li> <li>- И-Монголиа УТҮГ</li> <li>- ХувийнДата төвүүд</li> <li>- Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчид</li> <li>- ISP компаниуд</li> </ul>	
Харилцаа холбооны мэргэжлийн ангийн ахлагч	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн гүйцэтгэх захирал	<ul style="list-style-type: none"> <li>- Үндсэн сүлжээ эзэмшигчид</li> <li>- Үүрэн операторууд</li> <li>- Суурин операторууд</li> <li>- Шуудангийн үйлчилгээ эрхлэгчид</li> </ul>	

## БҮЛЭГ 2. ГАМШГААЛАХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ

### 2.1. Эрсдэлийн үнэлгээ

Штабын нь эрсдэлийн үнэлгээ хийх хамрах хүрээг тодорхойлох бөгөөд мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд хамаарах байгууллагауд Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмын дагуу эрх бүхий байгууллагаар хийлгэнэ. Мэргэжлийн ангиуд нь энэхүү эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.

Мэргэжлийн ангиуд нь мэдээлэл, харилцаа холбооны тасалдалгүй ажиллагааг хангах зорилгоор эрсдэлийн үнэлгээнд үндэслэн өөрийн төлөвлөгөөг боловсруулан, улсын албаар батлуулна. Төлөвлөгөөг батлуулахдаа штабаар хянуулсан байна. Энэхүү төлөвлөгөөний дагуу мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн бэлэн байдлыг хангах, дадлага сургуулилт жил бүр хийж, гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллана.

### 2.2. Гамшгийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо (MXX)-ны газрын зураглал

Гамшгийн үеийн MXX-ны тасалдалгүй, бэлэн байдлыг хангах зорилгоор урьдчилан сэргийлэх, төлөвлөх, сэргээн босгох үйл ажиллагаанд харилцаа холбооны орон зайн мэдээллийн системийг ашиглана. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн дэд бүтэц, үйлчилгээний талаарх бүх мэдээллийг энэхүү мэдээллийн системд мэдээлэл өөрчлөгдсөн тухай бүр шинэчлэн оруулж байна.

### 2.3. Гамшгийн үед мэдээлэл, харилцаа холбооны тэсвэрлэх чадвар, нөөц

Штабын орлогч дарга нь энэхүү төлөвлөгөөний 2.1-т заасан эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мэдээлэл, харилцаа холбооны гамшгийн үеийн нөөцийг бүрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана. Улсын албаны гишүүд нь гамшгийн үеийн нөөцийг бүрдүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

### 2.4. Олон улсын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, оролцогч талууд

#### Тамперын конвенц

Тамперын конвенц нь гамшгийн хор уршгийг бууруулах, аврах ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбоог ашиглах, түүний тасалдалгүй ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Монгол Улс 1998 онд Тамперын конвенцод нэгдэн орсон<sup>1</sup> байна. Тамперын конвенцод нэгдэн орсноор гамшигийн үед хариу арга хэмжээ авах, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний тасалдалгүй ажиллагааг хангахад шаардлагатай дотоод нөөц бололцоогүй болсон үед олон улсын дараах тусlamж, дэмжлэг авах боломж бүрдэх юм. Үүнд:

- Харилцаа холбооны, радио давтамжийн лицензүүдийг шуурхай олгох;
- Конвенцын хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн тоног төхөөрөмжийг түргэн шуурхай импортлох;
- Тусlamжийн ажилтнуудын эх орондоо ирэх, явах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Энэхүү конвенцыг ГХЯ, ЦХХХЯ, ОБЕГ хамtran соёрхон батлуулж, гамшигийн үед олон улсаас тусlamж, дэмжлэг авах боломжийг бүрдүүлсэн байх шаардлагатай бөгөөд ХХЗХ нь дараах зохицуулалтыг хийнэ . Үүнд:

- Тамперын конвенцын хүрээнд нийлүүлэгдэх харилцаа холбооны тоног төхөөрөмжийг радио давтамжийн тусгай зөвшөөрлийн болон бусад төлбөрөөс чөлөөлөх;
- Шаардлагатай тусгай зөвшөөрлүүдийг түргэн шуурхай олгох;
- Мэдээлэл, харилцаа холбооны нөөцийг цаг алдалгүй, түргэн, шуурхай нийлүүлэх зохицуулалтыг бий болгох.

## **НҮБ-ын байгууллагууд**

Монгол Улс 1961 онд НҮБ-д элссэн бөгөөд НҮБ-ын 2017-2021 оны Хөгжлийн тусlamжийн хүрээ баримт бичиг (UNDAF)-ээр НҮБ-ын Монгол дахь үйл ажиллагааг зохион байгуулдаг.

НҮБ-ын 15 агентлаг (НҮБ-ын Хүн амын сан, ОУХБ, ОУХМ, НҮБ-ын Хүүхдийн сан гэх мэт) нь Монгол Улсад гамшигийн менежментийг илүү үр дүнтэй хөгжүүлэхэд ашиглах техники, технологи, чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улс нь Тогтвортой хөгжлийн бүс нутгийн сансрын хэрэглээний хөтөлбөрөөр (RESAP) гишүүн бөгөөд уг хөтөлбөрөөр дамжуулан Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP) нь гамшигийн эрсдэлийг бууруулах, хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор сансрын технологи, GIS-н мэдээллийг гамшигийн үед улс орнуудад ашиглуулдаг. ESCAP нь гамшигийн үед сансрын агентлагуудын сүлжээг ашиглан тухайн бүс нутгийн хиймэл дагуулын зураг, гамшигийн дараах гео орон зайн зураг зэргийг гишүүн орнуудын хүсэлтээр нийлүүлдэг.

---

<sup>1</sup> United Nations Treaty Collection, 'Tampere Convention' (18 June 1998) <[https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg\\_no=XXV-4&chapter=25](https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XXV-4&chapter=25)>.

## Гамшгийн үеийн харилцаа холбооны кластер (ETC)

Гамшгийн үеийн харилцаа холбооны кластер (ETC) нь Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP) -н харьяа байгууллага бөгөөд гамшгийн үед хүн амыг мэдээллээр хангахад шаардлагатай харилцаа холбооны тоног төхөөрөмжийг нийлүүлэх, гамшгийн үед харилцаа холбоогоор хангах, мэдээллийг олон нийтэд хүргэх технологийн шийдлийг бий болгоход дэмжлэг үзүүлдэг.

### БҮЛЭГ 3. ГАМШГИЙН ҮЕИЙН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

#### 3.1. Гамшгийн үед ажиллах байгууллагуудын харилцан ажиллагааны зохицуулалт

Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу болон улсын алба, штаб, мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд холбогдох төрийн байгууллага, бусад улсын албадтай хамтран хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4. Гамшгийн үед ажиллах албадын хамтын ажиллагаа

№	Гамшгийн төрөл	Удирдан зохицуулах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Ой, хээрийн гал түймэр	ОБЕГ, БОАЖЯ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
2	Объектын гал түймэр	ОБЕГ, БОАЖЯ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
3	Газар хөдлөлт	ОБЕГ, Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
4	Үер	ОБЕГ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
5	Ган	ОБЕГ,ХХАЯЯ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
6	Хүчтэй цасан болон шороон шуурга	ОБЕГ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
7	Мал, амьтны гоц халдварт өвчин гарах	ОБЕГ, ХХАЯЯ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
8	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний тасалдал	Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
9	Эрчим хүчний үйлчилгээний тасалдал	ЭХЯ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги


10	Кибер халдлага	Кибер аюулгүй байдлын газар, Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги
11	Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн ёе	ОБЕГ Мэдээлэл, харилцаа холбооны улсын алба	УОК, Штаб, Мэргэжлийн анги, Бусад салбарын штаб, мэргэжлийн анги

### 3.2. Гамшигийн үеийн зарлан мэдээлэл

#### 3.2.1 Улсын алба, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг цуглуулах

Гамшигийн үед Улсын алба, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг цуглуулахдаа Хүснэгт 10-т заасан мэдээллийн дагуу зарлан мэдээллийг хүргэнэ. Бие бүрэлдэхүүн мэдээлэл авмагц 30 минутын дотор Улсын албаны даргын заасан газарт цугларна. Зураг 2-т Улсын алба, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг цуглуулах бүдүүвчийг харуулав.

Зураг 2. Улсын алба, штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг цуглуулах бүдүүвч



### 3.2.2. Бүх нийтэд зарлан мэдээлэх

Гамшгийн үеийн зарлан мэдээлэх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу зохион байгуулна.

Бүх нийтэд гамшиг, аюулт үзэгдэл, ослын талаарх мэдээг зарлан мэдээлэхдээ Үүрэн холбооны систем, Телевиз, радиогийн систем, Зарлан мэдээллийн цамхгийн системийг ашиглана. Мэргэжлийн ангиуд нь ОБЕГ-тай хамтран дээрх системүүдийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллана. Улсын алба нь энэхүү системүүдийг бий болгох, байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг УОК-оор шийдвэрлүүлнэ

### 3.3. Хүч хэрэгслийг төлөвлөх, хуваарилах

Хангалтын мэргэжлийн анги нь хүч, хэрэгсэл, нөөцийг бүрдүүлэх, хуваарилах ажлыг зохион байгуулна. Мэргэжлийн ангиуд нь эрсдэлийн үнэлгээнд үндэслэн өөрийн анgid шаардлагатай хүч, хэрэгсэл, нөөцийн мэдээллийг гаргаж, Хангалтын мэргэжлийн анgid хүргүүлнэ. Эдгээр мэдээлэлд үндэслэн Хавсралт 9-д заасан хүч, хэрэгслийн мэдээллийг тухай бүр шинэчилнэ.

Хангалтын мэргэжлийн анги нь гамшгийн үед хүн хүч, техник хэрэгслийг дайчлан ажиллуулах төлөвлөгөөг Хүснэгт 5-д заасны дагуу боловсруулж Улсын албаар батлуулан, хүч хэрэгслийг оновчтой хуваарилах ажлыг зохион байгуулна.

*Хүснэгт 5. Гамшгийн үед хүн хүч, техник хэрэгслийг дайчлан ажиллуулах төлөвлөгөө*


№	Мэргэжлийн ангийн нэр	Гашгийн үед гарах гэмтэл	Бэлэн байдалд шилжих хугацаа /цаг, минутаар/	Байгууллагын нэр	Дайчлагдах хүний тоо	Багаж хэрэгслийн нэр, тоо	Багаж хэрэгслийн загвар, хүчин чадал,тоо	Техник хэрэгслийн тоо	Хариуцах албан тушаалтан
1	...								

### 3.4. Мэдээ, мэдээлэл цуглуулах дамжуулах

Улсын албанаас өгсөн цагийн мэдээ, үүрэг даалгаврыг Штабын дарга өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэж, шаардлагатай мэдээ, мэдээлэл, үүрэг даалгаврыг Мэргэжлийн ангийн нарийн бичгээр дамжуулан мэргэжлийн ангиудад хүргүүлнэ.

Мэргэжлийн ангиудын ахлагч нь гишүүдээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх мэдээ болон цагийн мэдээг авч Мэргэжлийн ангийн нарийн бичиг /ЦХХХЯ-ны Харилцаа холбооны дэд бүтцийн хэрэгжилтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/-д дамжуулна. Мэргэжлийн ангийн нарийн бичиг, Гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар хамтран цаг үеийн мэдээ, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг боловсруулан штабын даргад танилцуулна. Штабын дарга нь нэгдсэн тайлан мэдээг Улсын албаны даргад танилцуулна. Зураг 3-т Мэдээлэл хэрхэн дамжуулахыг харуулав.

Зураг 3. Мэдээлэл дамжуулах



## БҮЛЭГ 4. СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ

Салбарын хохирлын хэмжээ нь дотоод нөөц боломжийн хүрээнд байна гэж үзвэл тухайн гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн хүчээр зохион байгуулна. Харин гамшгийн хохирол нь тухайн салбарын дотоод нөөц боломжоос давсан тохиолдолд орон нутгийн болон Улсын онцгой комиссын оролцоотойгоор сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулна. Хүснэгт 6-д Сэргээн босгох төлөвлөгөөг харуулав.

*Хүснэгт 6. Сэргээн босгох төлөвлөгөө*

Үйл ажиллагаа	Хугацаа	Үдиридан зохион байгуулах	Дэмжлэг үзүүлэх байгууллага
<b>A. Богино хугацаанд</b>			
Гамшгийн улмаас учирсан хохирлын үнэлгээ хийх	Ц+24	Штаб	Мэргэжлийн ангиуд
Сэргээн босгох төлөвлөгөө гаргах	Ц+5	Штаб	Мэргэжлийн ангиуд
Сэргээн босгоход шаардагдах нөөц зардал, хөрөнгийг тодорхойлох, шийдвэрлүүлэх	Ц+24	Улсын алба	Штаб
Хүч хэрэгслийг дайчлах	Ц+5	Штаб	Мэргэжлийн ангиуд
Харилцаа холбоог сэргээн засварлах	Ц+24	Штаб	Мэргэжлийн ангиуд
<b>B. Дунд хугацааны</b>			
Гамшгийн үед гарсан нийт хохирлын хэмжээг нарийвчлан тогтоох	Гамшгийн дараа 1 сарын дотор	Штаб	Мэргэжлийн ангиуд
Хүчитгэх шаардлагатай дэд бүтцийн мэдээлэл, хөрөнгө оруулалтын тооцоог гаргах	Гамшгийн дараа 2 сарын дотор	Штаб	Мэргэжлийн ангиуд
Дунд хугацааны сэргээн босгох төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Гамшгийн дараа 2 сарын дотор	Улсын алба, Штаб	Мэргэжлийн ангиуд
Сэргээн босгоход шаардагдах зардал, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	Гамшгийн дараа 3 сарын дотор	Штаб, Хангалтын мэргэжлийн анги	Мэргэжлийн ангиуд
Дунд хугацааны сэргээн босгох төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Гамшгийн дараа 1 жилийн дотор	Штаб, Мэргэжлийн ангиуд	
<b>C. Урт хугацааны</b>			
Эрсдэлийн үнэлгээ хийх	3 жил тутам	Штаб	Мэргэжлийн ангиуд
Гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Тухай бүр	ЦХХХЯ, Улсын алба, Штаб	Мэргэжлийн ангиуд
Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	Тухай бүр	Улсын алба	Мэргэжлийн ангиуд
Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах дадлага, сургуулд тийшүүлж хийх	Жил бүр	Штаб, Хангалтын мэргэжлийн анги	Мэргэжлийн ангиуд